

# International Theatre Institute ITI

World Organization for the Performing Arts



Олон улсын Бүжгийн өдөр 2026 – 04 - 29

Кристал Пайт-н намтар, Канад

Бүжиг дэглээч

Монгол (орчуулга)

---

Канадын бүжиг дэглээч Кристал Пайт нь Бритиш Колумбия Балет, Уиллям Форсайтын балет Франкфурт театрын үндсэн гишүүн байв.

Бүжиг дэглэгчээр 35 жил ажиллахдаа Пайт нь Роял Балет, Голлоандын Бүжгийн театр, Парисын дуурь бүжгийн театр, Канадын балетын үндэсний театр зэрэг байгууллагуудад жар гаруй бүтээл туурвижээ. Тэрээ бүтээлдээ траума, донтолт, зөрчил, ухамсар ба үхэл гэх мэт асуудлуудыг зоригтой хөнддөгөөрөө алдартай төдийгүй түүний зоримог бөгөөд анхдагч зорилго нь олон улсын түвшинд нэр хүндтэй болсон ба энэ чанараараа тэрээр бүжгийн салбарын дараа залуу уран бүтээлчдийг урамшуулан зоригжуулж байдаг.

Тэрээр Голлоандын Бүжгийн театр, Садлерын Уэлс (Лондон) болон Канадын үндэсний урлагийн төв хэмээх гурван байгууллагад уран сайхны зөвлөхөөр ажиллаж байна. Тэрээр Саймон Фрефзерийн Их сургуулийн Дүрслэх урлагийн хүндэт доктор, Канадын Одонгийн гишүүн, мөн Францын Утга зохиол, Урлагийн хүндэт мастер өргөмжлөлтэй.

Тэрээр 2002 онд Ванкуверт хүн төрөлхтний амин чухал хэсгүүдийг холбоход түгээмэл асуудлуудыг ойлгон урлагийн бүтээл рүү хөрвүүлэн хүргэх зорилгоор Кидд Пайвот компанийг үүсгэн байгуулжээ. Кидд Пайвот компани нь бүжиг болон театрын радикал хосолмол арга барил бүхий *Betroffenheit*, *Revisor*, (Жонатан Янгтай хамтран бүтээсэн) *Assembly Hall*, *The Tempest Replica*, *Dark Matters*, *Lost Action*, *The You Show* зэрэг дэлхийд алдартай бүтээлүүдээрээ олон улсад аялан тоглолт хийсээр байна.

Пайт олон шагнал хүртсэн ба үүнд Канадын гүйцэтгэх урлагийн Ерөнхий сайдын шагналыг 2022 онд, Жакобын Пиллоу Бүжгийн шагналыг 2011 онд, Канадын зөвлөлийн Жаклин Лемю шагналыг 2012 онд авсан шагналууд зүй ёсоор багтдаг. Парисын Дуурь Бүжгийн театрт тавьсан *The Seasons' Canon* бүтээлээрээ 2017 онд тэрээр Benois de la Danse шагнал, 2018 онд Grand Prix de la danse de Montréal шагнал хүртсэн байна. Роял балет болон Кидд Пайвот театруудад бүтээсэн бүтээлүүдээрээ тэрээр Сер Лауренс Оливьерын шагналаар таван удаа шагнуулжээ.